

# ДААТГУУЛАГЧ (ИРГЭН) ТА МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ УЛМААС ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ ЧАДНА



## Мэргэжлээс шалтгаалсан өвчний үүсэх шалтгаан:

Хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин гэнэ.




Үйлдвэрлэлийн тоос, тоосонцор; Ажлын орчны чийглэг, агаарын хэм хөдөлгөөн, даралт, доргион, шуугиан, инфра ба ультра долгион, ионжуулагч ба ионжуулагч бус цацрагб

Химийн бодисууд



Биеийн хүчний болон мэдрэл сэтгэцийн эрхтэн тогтолцооны хэт ачаалалб



Биологийн нян, вирус, мөөгөнцөр, ургамал, амьтны гаралтай бүтээгдэхүүн.

# Хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэж буй өвчлөлүүд:

- Уушги тоосжих өвчин
- Химийн бодисын архаг хордлого
- Нүдний өвчин
- Харшилт өвчин
- Доргионы өвчин
- Туяаны өвчин
- Тулгуур тогтолцооны өвчнүүд
- Шуугианаас сонсгол бууралт



## Хөдөлмөрийн нөхцөлийн ангилал

Хэвийн хөдөлмөрийн нөхцөл:

Үйлдвэрлэлийн ажлын байрны орчны болон хөдөлмөрийн үйл ажиллагааны хүчин зүйлс нь ажилтны эрүүл мэндэд нөлөөлөхгүй буюу тэдгээрийн хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөх хэмжээнээс хэтрээгүй байх нөхцөл.

Хэвийн бус нөхцөл:

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагын хүрээнд сөрөг нөлөөллийг нь арилгах боломжгүй, хөдөлмөрийн стандартад нийцээгүй ажлын байрны нөхцөл.



# Мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэлт

- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулж, үйлдвэрлэлийн орчны эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд хяналт тавих
- Ажилтныг амрах байр, шүршүүр, ундны цэвэр усаар хангах нөхцөл боломжийг бүрдүүлэх
- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ жил бүр хийлгэх;
- Ажилтныг анх ажилд орох үед эрүүл мэндийн үзлэгт заавал хамруулж, тухайн ажилд тохирох эсэхийг шийдэх
- Ажилтныг жил бүр эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж мэргэжлээс шалтгаалсан өвчин илрүүлэх үзлэг хийлгэх
- Ажилтныг чанартай сайн хувийн хамгаалах хэрэгслээр, хүрэлцэхүйц хэмжээгээр хангах.

---

## Хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдолд таны анхаарах зүйлс

- Хяналтын эмчийн заавар зөвлөгөөг сайтар биелүүлж холбогдох үзлэг шинжилгээнд тогтмол хамрагдаж байх
- Амьдралын зөв хэв маяг, дадалд хэвших
- Архи тамхинаас татгалзах
- Дасгал хөдөлгөөн хийх
- Эрүүл хооллох
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссийн шийдвэрээр сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдах хөдөлмөр эмчилгээ, хөдөлгөөн эмчилгээ, сэтгэл зүйн эмчилгээнд хамрагдах
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссийн шийдвэрээр хориглосон хөдөлмөрийн нөхцөлд ажиллахгүй байх
- Дахин мэргэшүүлэх сургалтад хамрагдах.

**ТА ӨӨРӨӨ ӨӨРИЙНХӨӨ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАЙРЛАХ,  
ХАМГААЛАХ, ДЭМЖИХ ҮҮРЭГТЭЙ.**